Хичээлийн контент хэсэг

Цахим контент байршуулах заавар

1. Багш та өөрийн боловсруулахаар сонгосон нэгж хичээлийн эхний 2 ээлжит хичээлийг medle.mn сургалтын цахим системд байршуулахдаа «Миний цонх» хэсгээр “Миний оролцох хичээл” хэсгээр хандаарай.
2. Сонгосон анги судлагдахууныг сонгоход түүнд харгалзах нэгж хичээл дараах зурагт харуулсан байдлаар гарч ирнэ.



Текстийн фонтыг тохируулах.

Medle.mn-д агуулга байршуулахдаа текстийн хувьд дараах форматыг баримтална. Үүнд:

1) Том гарчгийг Times new roman фонт, 24pt хэмжээтэй, bold хэлбэрээр бичнэ.
2) Дэд гарчгийг Times new roman фонт, 18 pt хэмжээтэй бичнэ.
3) Эхлэл болон үндсэн хэсгийн агуулгын текстийг Times new roman фонт, 14pt хэмжээтэй бичнэ.



Текстийн үсгийн фонтыг сонгохдоо текстээ идэвхжүүлээд Paragraph хэлбэрийг сонгосон байна. Үүний дараа дараах зааврын дагуу текстийн форматыг тохируулаарай. Үүнд:

1. Текстийн фонт сонгох — Format -> Fonts -> Times new roman

Текстийн хэмжээ сонгох - Format -> Font sizes -> 24, 18,14 хэмжээнээс дээр заасан форматыг дагуу сонгоно.

Текстийн өнгийг тохируулах.



Текстийн өнгийг сонгох — Format -> Text color хэсгээс сонгоно. Ингэхдээ гарчгийг бараан хөх өнгөөр, бусад текстийг хар өнгөөр тохируулна.

Текстийн мөр хоорондын зайг тохируулах.

1. Текстийн мөр хоорондын зайг тохируулахдаа

   Format -> Line height -> 1 эсвэл 1,5 аль тохиромжтойг нь сонгоорой.



Зураг, видео байршуулах

1. Зурагт харуулсны дагуу файл оруулах товч дээр товшин компьютер дээр байгаа файлаа зааж оруулж ирнэ.



Урьдчилан үзэх



Батгатгал хэсэг

Бататгал хэсэгт зөвхөн асуулт оруулна. Асуултын хэлбэрийн хувьд нэг сонголттой, **Олон сонголтой**, **Холбох буюу харгалзуулах** асуултуудыг оруулах боломжтой. Мөн зурагт харуулсны дагуу асуулт болон хариултуудад зураг оруулах боломжтой.



Бататгал хэсэгт зураг оруулахдаа дараах хэмжээг баримтлаарай. Үүнд

⇒ Асуулт хэсэгт оруулах зургын өндөр—380, урт– 600-аас ихгүй

⇒ Хариулт хэсэгт оруулах зургын өндөр—110, урт—200-аас ихгүй байх нь тохиромжтой байна.